ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН МАГАДЛАГЧ ЭМЧ,МЭРГЭЖИЛТЭН
РЭНЦЭНГИЙН САРАНТУЯАГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** ***Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1:*** *"Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | 86% | 90% доошгүй | Монгол улсын засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177 А/433 тоот хамтарсан тушаал бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Улсын 3-р төв эмнэлэг, Төмөр замын эмнэлэг, Эх нялхасын эрдэм шинжилгээний үндэсний төв, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв болон 34 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хууль журмыг танилцуулан сургалтуудыг тасралтгүй зохион байгуулсан.<br>Үр дүн: 39 байгууллагын давхардсан тоогоор 256 эмч эмнэлгийн ажилтныг мэдээлэл арга зүйгээр хангаж, зөвлөгөө чиглэлийг хүргүүлэн ажилласан. | 2025.01.02<br>-<br>2025.12.31 | |
| **Зорилт 4.** ***Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 4.1.** Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | | 86% | 90% доошгүй | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны Ажлын хариуцлага, сахилага, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай 01 тоот албан даалгавар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны Чиглэл хүргүүлэх тухай 01/1136 тоот албан бичиг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1244 тоот албан бичиг, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны Чиглэл хүргүүлэх тухай 09/12 тоот бичиг, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны 06 сарын 06-ний өдрийн 09/77 тоот албан бичгийн дагуу тайлангуудыг эрүүл мэндийн магадалын төв комисcд албан бичгийн хамт хүргүүллээ. | 2025.01.02 - 2025.12.31 | |
| 2. | **Арга хэмжээ 4.2** Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах | - | 86% | 90% доошгүй | Иргэдээс эмнэлгийн хуудас олгох тухай 2 өргөдөл ирж хуулийн дагуу гомдол саналгүй шийдвэрлэсэн. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг нэмэх тухай 4 өргөдөл ирж хуулийн дагуу шийдвэрлэж ажиллаа. | 2025.01.02 - 2025.12.31 | |
| *Зорилт 4.3. Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 4.3.1** Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байна. | - | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байх. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах талаар дараах арга хэмжээ зохион байгуулсан.<br>Үүнд:<br>-Нарийн мэргэжлийн эмч нар болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын иргэний эрүүл мэндийн картын бичилтийг шинжилгээ, оношилгоо, үзлэгт үндэслэн эпикризийг тодорхой зөв бичих талаар мэдээлэл, зөвлөмж өгч 2-р улиралд уралдаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>-Хурлаар иргэн/даатгуулагч/-г оруулах эмч нарын цагийн хуваарийг гарган батлуулж, цаг үеийн мэдээллийг цахим сүлжээгээр дамжуулан хүргэж ажиллаж байна.<br><br>-Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зорилгоор нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ижил мэргэжилтний үзлэгийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 14 цагт Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын хурлын танхимд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн Магадлагч эмч, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй баг очиж оролцлоо. Тайлангаа хугацаандаа Эрүүл мэндийн төв зөвлөлд хүргүүсэн. | 2025.01.02<br>-<br>2025.12.31 | |

<table>
<tr><td>4.</td><td>Арга хэмжээ 4.3.2 Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх</td><td></td><td>100%</td><td>100%</td><td>Баянгол дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон иргэдийн тоог (2024 он 12 сарын 31-ны байдлаар програмд 5562 иргэн, дүүргийн нийт хүн амын тоотой (252979) харьцуулбал хүн амын 2,1 хувийг эзэлж байна. Тус дүүрэгт дотор, мэдрэл, чих хамар хоолой, нүд, гэмтэл, мэс заслын /хавдар/ эмгэгүүд эхний 6 байрыг эзэлж байгаа бөгөөд эдгээр нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 21,3 хувийг эзэлдэг. 2024 онд 5562 иргэн хөдөлмөрийн чадвар алдалттай байсан бөгөөд тэргүүлэгч 5 өвчлөлийг дүүргийн эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулбал:
<table>
<tr><th>Өвчлөл</th><th>ЭМТ-н нийт үзлэг</th><th>ХЧА шинээр тогтоосон</th><th>Эзлэх хувь</th></tr>
<tr><td>Дотор</td><td>18073</td><td>98</td><td>0,5%</td></tr>
<tr><td>Мэдрэл</td><td>12166</td><td>40</td><td>0.3%</td></tr>
<tr><td>Гэмтэл</td><td>11658</td><td>52</td><td>0.4%</td></tr>
<tr><td>Чих хамар хоолой</td><td>1905</td><td>6</td><td>0.3%</td></tr>
<tr><td>Нүд</td><td>4529</td><td>21</td><td>0.4%</td></tr>
</table>
Үр дүн: Баянгол дүүргийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалт нь улсын дунджаас доогуур нийт хүн амынхаа 2,1 хувийг эзэлж байна.</td><td>2025.01.02<br>-<br>2025.12.31</td><td></td></tr>
<tr><td>5.</td><td>Арга хэмжээ 4.3.3 Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан</td><td>Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг</td><td>100%</td><td>100%</td><td>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийг авлигын эсрэг хуулиас урьдчилан сэргийлж ажиллахыг уриалан брошур самбарыг байршуулан ажиллахын сацуу 2025 оны 1 сард Авлигын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад бүх</td><td>2025.01.02<br>-<br>2025.12.31</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. | | | гишүүдийг цахимаар, 2025.05.12 өдөр Авлигын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад магадлагч эмч нар танхимаар, 2025.05.28 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэглээ, авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад танхимаар тус тус оролцсон.<br><br>Үр дүн:Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Газраас зохион байгуулсан сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдах. | Тухай бүр | 100% | 100% | | 2025.01.02 - 2025.12.31 | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдах | Тухай бүр | 66% | 100% | 2025 оны 1 сард Авлигын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад<br>2025.05.12 өдөр Авлигын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад магадлагч эмч нар танхимаар,<br>2025.05.28 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэглээ, авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад танхимаар | 2025.01.02 - 2025.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 3.** Эмчийн эмчлэх эрхийн кредит сургалтанд хамрагдах | Жилийн 6 кредитийн сургалтанд хамрагдах | 100% | 100% | Кредит сургалтандаа бүрэн хамрагдсан. | 2025.01.02 - 2025.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
МАГАДЛАГЧ ЭМЧ
....................................
*( Албан тушаал )*

................................ / Р.САРАНТУЯА /
*( Нэр, гарын үсэг )*

......... ......... .........
*( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР

**Нэмэлт үүрэг даалгавар**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 1.** Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаарх сургалтыг ААНБ, ОН-н байгууллагад хийх, зохион байгуулах | Баянгол дүүрэг үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах | | | Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулснаар эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажилллагааны талаарх ойлголт нэмэгдэж, баримталж буй бодлого, тушаал шийдвэрийн хэрэгжилт, хууль эрх зүйн мэдлэг сайжирч, эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны үеэр тохиолддог аливаа асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, нийтлэг алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлж, эргэх холбоотой багаар хамтарч ажиллах чадварт суралцах, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн даатгуулагчийн эрхийг хамгаалах, эрүүл мэндийг нөхөн сэргээх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Хөдөлмөрлөх, хөгжих эрхийг баталгаажуулж хүн бүрийн нийгмийн оролцоог хангах, хүний эрхийн талаар зөв ойлголт хандлагыг нийгэмд төлөвшүүлсэн цогц арга хэмжээ боллоо. | 2025.01.02-2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 2**. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх ЭММЗөвлөлөөс зохион байгуулсан Ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулах удирдамж гарч нийт эмч нар оролцох | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зорилгоор нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ижил мэргэжилтний үзлэгийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 14 цагт Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын хурлын танхимд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн Магадлагч эмч, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй баг очиж оролцох. | | - | Үзлэгт оролцсон багуудын эмч нар Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн санд бүртгэлтэй даатгуулагч, хүний амбулаторийн карт болон эрүүл мэндтэй холбоотой бичиг баримтад тулгуурлан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/293, А/133 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавар”-ын дагуу үнэлгээгамжилттай хийлээ. | 2025.01.05-2025.06.14 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 3**. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх ЭММЗөвлөлөөс зохион байгуулах | Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-27-ны өдрийг хүртэл Баянгол дүүрэгт Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалыг зохион байгуулах | - | - | Тус дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь чих, хамар, хоолойн өвчний улмаас даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхдээ оношийн үндэслэл хангалтгүй байхад шийдвэрлэж байгаа нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, эрүүл мэндийн магадлалтай холбоотой дүрэм, журмыг зөрчиж байгаа хэдий ч бусад үйл ажиллагаанд бусад аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдэд жишиг болохоор ололттой талууд байгаа тул үйл ажиллагааг хэвийн гэж дүгнэв. | 2025.01.02-2025.06.30 | |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

МАГАДЛАГЧ ЭМЧ: ........................................ / Р.САРАНТУЯА / ......... ......... .........

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТЭТГЭВЭР,ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........................................ / Б.СУГАР / ......... ......... .........

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )